



ТӨВ АЙМАГ  
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 03 өдөр

Дугаар A/90

Бүрэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь заалт, Төв аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/266 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Хатан туулын хурд-2023" аймгийн зэрэглэлтэй бүсийн хурдан морины уралдааныг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Отгонхишигт

(Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Б.Болорцэцэг

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Г.Ундрас-Эрдэнэ

(Соёлын төвийн дарга)

Н.Хүрэлбаатар

(Мал эмнэлгийн улсын байцаагч)

Ц.Лхагва

(1-р багийн Засаг дарга)

З.Пүрэв-Очир

(Баянцогт 2-р багийн Засаг дарга)

Д.Батмөнх

(Монгол 3-р багийн Засаг дарга)

Д.Батмөнх

(Эрдэнэхангай 4-р багийн Засаг дарга)

Б.Оюун-Эрдэнэ

(Өнжүүл 5-р багийн Засаг дарга)

Ц.Цэдэвсүрэн

(Ерөнхий боловсролын сургуулийн бичиг хэргийн ажилтан)

Д.Мөнхзул

(Эрүүл мэндийн төвийн дарга)

П.Анхцэцэг

(Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Г.Энхцэцэг

(Хөдөлмөр, халамж үйлчилгээний мэргэжилтэн)

412305204

Н.Түвшинжаргал  
(Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)  
П.Цэцэнбаяр  
(Нягтлан бодогч)  
Т.Мөнхбат  
(Хэсгийн төлөөлөгч)  
Э.Очирсүх  
(Цагдаа)

2.Уралдааны бэлтгэл зохион байгуулалтыг бүрэн хангаж, унаач хүүхдийн гэнэтийн ослын даатгалд хамрагдалт, хамгаалах хувцас хэрэглэл өмсөх, насны хязгаар зэрэгт хяналт тавьж, уралдааны зам, гарцааны төхөөрөмжийг урьдчилан үзэж, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3.Уралдааны үеэр нийгмийн хэв журмын зөрчил гаргуулахгүй байх арга хэмжээ авч ажиллахыг цагдаагийн Хэсгийн төлөөлөгч (Т.Мөнхбат), цагдаа (Э.Очирсүх) нарт даалгасугай.

4.Уралдааны явцад унаач хүүхэд, хурдан морины аюулгүй байдлыг хангаж, малын гоц халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийг төвийн дарга (Д.Мөнхзул), Мал эмнэлэгийн Улсын байцаагч (Н.Хүрэлбаатар)нарт үүрэг болгосугай.

Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Пүрэв-Очир)-д даалгасугай.

